



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 96

Хэрлэн сум

Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэх тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.1.1, 46.1.2, 46.6, 62 дугаар зүйлийн 62.1, 62.1.4 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ын 2.1.4, 2.1.5, 3.1.2, 3.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албан хаагчдыг төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэсүгэй.

2. Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэх албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.


3. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын дагуу нийт албан хаагчдыг нөөцийн бүртгэлд бүртгэхийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Ж.Саруултөгс)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн
2024 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн
96 дугаар тогтоолын хавсралт



Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэх албан хаагчдын жагсаалт

№	Албан тушаалтны овог, нэр	Албан тушаал	Нөөцөд бүртгэх үндэслэл
1	Тогоонтөмөрийн Батдорж	Хэнтий аймгийн Шүүхийн шинжилгээний албаны нягтлан бодогч, цагдаагийн дэслэгч	Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2 дахь заалт. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын 2021 оны Б/386 дугаар тушаалаар 6 сараас дээш хугацаагаар суралцах болсон тул чөлөөлсөн.
2	Ганбаатарын Мөнхбат	Хөдөлмөрийн хэлтсийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл хариуцсан мэргэжилтэн	Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, 27 дугаар зүйлийн 27.2.4 дэх заалт. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2016 оны Б/18 дугаар тушаалаар Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс, Хөдөлмөрийн хэлтсүүдийг нэгтгэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар байгуулагдсан тул чөлөөлсөн.
3	Нарангэрэлийн Энхмаа	Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2 дахь заалт. Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны Б/04 дүгээр тушаалаар 6 сараас дээш хугацааны сургалтад бэлтгэгдэх шаардлагатай болсон тул чөлөөлсөн.
4	Энхбаатарын Баттөр	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн Өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн	Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.1 дэх заалт. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2017 оны Б/20 дугаар тушаалаар удаан хугацаагаар биеэ эмчлүүлэх шаардлагын улмаас чөлөөлсөн.
5	Туяагэрэлийн Бямбабаатар	Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга	Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.1 дэх заалт. Хэрлэн сумын Засаг даргын 2016 оны Б/220 дугаар захирамжаар эрүүл мэндийн байдлын улмаас албан ажлаа хийхгүйгээр эмчлүүлэх болсон тул чөлөөлсөн.

6	Батхуягийн Өнөрцолмон	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн Залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн	Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.1 дэх заалт. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн даргын 2017 оны Б/05 дугаар тушаалаар эрүүл мэндийн байдлын улмаас албан ажлаа хийхгүйгээр эмчлүүлэх шаардлагатай болсон тул чөлөөлсөн.
---	--------------------------	---	--

---oOo---